СУДАЛГААНЫ АЖЛЫН АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ

Т. Батбямба Доктор (Ph.D)

batbyamba@msue.edu.mn

2026.11.25

Судалгааны ажлын бүтэц

Хэсэг	Агуулга
1. Сэдэв	Судалгааны объект, эх хэрэглэгдэхүүн, (арга)
2. Удиртгал	Үндэслэл, судлагдсан байдал, судалгааны асуулт, зорилго, зорилт, эх хэрэглэгдэхүүн, онол, арга зүй ба арга, шинэлэг тал, ач холбогдол
3. Үндсэн хэсэг	Зорилт бүрд нэг бүлэг: ойлголт, жишээ, хүснэгт, тайлбар, дэд дүгнэлт
4. Дүгнэлт	Зорилт бүрийн хариулт, таамаглал, хязгаарлалт, цаашдын судалгаа
5. Ном зүй	Эш татсан бүтээл бүр, нэг загвараар
6. Хавсралт	Үндсэн хэсэгт багтаагүй хүснэгт, жагсаалт, асуулга

Жишээ болгох өгүүлэл

Б. Лхагвачимэг

С. Чойсүрэнгийн туульсын баатруудын нэр, нэршлийн өвөрмөц чимэг үгийн судалгаа

Эрдмийн хэлхээ, XV боть, 2026, х. 172–184

Сэдэвт юу орох вэ?

- Судалгааны объектыг тодорхой нэрлэсэн байна.
- Эх хэрэглэгдэхүүн, хүрээг заасан байна.
- Судалгааны арга, хандлагыг илэрхийлж болно.
- Хэт өргөн биш, нэг өгүүлэлд багтахуйц байна.
- Зорилготойгоо нийцсэн байна.
- Товч, ойлгомжтой, нэр томьёог зөв хэрэглэсэн байна.

Жишээ нь: сэдэв

«С. Чойсүрэнгийн туульсын баатруудын нэр, нэршлийн өвөрмөц чимэг үгийн судалгаа («Галзуу хар хөхөл», «Эзэн улаан бодон», «Бужин даваа хаан» туулийн жишээн дээр)»

(х.172)

Сэдвийн бүрэлдэхүүн	**Энэ өгүүлэлд**
Судалгааны объект	баатруудын нэр, нэршлийн өвөрмөц чимэг үг
Хүрээ (хэний)	туульч С. Чойсүрэн
Эх хэрэглэгдэхүүн	гурван тууль — дэд гарчигт нэрлэсэн

Удиртгалд юу орох вэ?

- Судалгааны сэдвийг сонгосон үндэслэл, тулгамдсан асуудал
- Судалгааны зорилго, зорилт
- Судалгааны объект, эх хэрэглэгдэхүүн
- Судлагдсан байдлын тойм, өмнөх судалгаанаас ялгарах тал
- Судалгааны арга зүй, хэрэглэсэн арга
- Судалгааны шинэлэг тал, ач холбогдол

(1) Хэсэг бүр ямар асуултад хариулдаг вэ?

Хэсэг	**Хариулах асуулт**	**Жишээ: Лхагвачимэгийн өгүүлэл**
Үндэслэл	Ямар асуудал байна? Яагаад судлах шаардлагатай вэ?	Алтайн урианхайн нэрт туульч С. Чойсүрэнгийн тууль хайлах хувийн онцлог, хэл найруулга нь тодорхойлогдоогүй
Судлагдсан байдал	Хэн, юуг, ямар аргаар судалсан бэ? Юу судлагдаагүй, ямар хоосон зай үлдсэн бэ?	1960–2010 оны 10 гаруй бүтээл; *«…үйл явдлыг товчлох, … баатрыг ерөнхийлөн дүгнэхээс хэтрээгүй байна»* (х.173)
Судалгааны асуулт	Судалгааны төгсгөлд хариулах асуулт юу вэ? (асуултын хэлбэрээр)	Тусад нь бичээгүй, зорилгод далд байна. Асуулт болговол: «С. Чойсүрэн баатраа нэрлэхдээ хэвшмэл хэллэгийг ямар зүй тогтолтой хэрэглэдэг вэ?»
Зорилго	Энэ асуултад хариулснаар юуг мэдэх, батлах эсвэл бүтээх вэ?	*«…үүнд үндэслэн С. Чойсүрэнгийн тууль хайлах онцлогийг тодорхойлох юм»* (х.174)
Зорилт	Зорилгод хүрэхийн тулд ямар 3–5 дэд асуудлыг шийдэх вэ? (зорилт бүр нэг дэд асуултын хариу)	1) нэрийн давтамжийн нягтыг тодорхойлох; 2) өргөтгөсөн чимэг үг ямар тохиолдолд илрэхийг тодорхойлох; 3) гурван туульд ижил зүй тогтол буй эсэхийг шинжлэх (х.174)

(2) Хэсэг бүр ямар асуултад хариулдаг вэ?

Хэсэг	**Хариулах асуулт**	**Жишээ: Лхагвачимэгийн өгүүлэл**
Эх хэрэглэгдэхүүн	Ямар эх, хэвлэл дээр, хэр хэмжээнд, яагаад үүнийг сонгосон бэ?	«Нэрт туульч С. Чойсүрэнгийн туульс» (2010)-ээс 3 тууль: 1938, 2246, 4725 мөр; урт нь өөр, өгүүлэмж нь төстэй (х.174)
Онол	Ямар онол, үзэл баримтлалд тулгуурлах вэ? Гол ойлголтоо хэрхэн тодорхойлж, эхэд юугаар таних вэ?	Парри–Лордын аман хэвшил тогтолцоо; хэвшмэл хэллэг = *«давтагдах шинж бүхий хэвшин тогтсон холбоо үг»*; эхэд: баатрын нэр, нэршил (х.174–175)
Арга зүй	Ямар хандлагаар (тоон, чанарын, холимог), ямар дарааллаар ажиллах вэ?	Тоон ба чанарын; нягт тооцох → чимэг үг бүртгэх → зүй тогтол харьцуулах (х.172, 174)
Арга	Мэдээллийг хэрхэн цуглуулж, яаж шинжлэх вэ? (арга: тоолох, ангилах, туршилт, ярилцлага; хэрэгсэл: Excel, Praat…)	Мөр тоолох, нягтын томьёо; тохиолдлыг бүтэц, нөхцөлөөр нь ангилах (Хүснэгт 2–4) (х.175–179)
Шинэлэг тал, ач холбогдол	Шинээр юу нэмэх вэ? Үр дүнг хэн, юунд ашиглах вэ?	Шинэлэг талыг тусгайлан бичээгүй. Ач холбогдол зөвхөн хураангуйд: *«…хувь туульчийн тууль хайлах онцлогийг судлах…»* (х.172)

Жишээ нь: судлагдсан байдал

- 1960–2010 оны 10 гаруй бүтээлийг он дарааллаар тоймолсон
- Нэгтгэн дүгнэсэн: судалгаа «үйл явдлыг товчлох, баатрыг ерөнхийлөн дүгнэхээс хэтрээгүй»
- Тиймээс энэ өгүүлэлд: нэршлийн давтамжийг тооцоолж, зүй тогтлыг гаргана

Тойм → дутуу зүйл → миний судалгаа

Зорилго, зорилт, алхам

	Юу вэ	**Хэрхэн бичих**	**Жишээ**
Зорилго	Эцсийн үр дүн, нэг өгүүлбэр	«…-ыг тодорхойлох (харьцуулах, шалгах, боловсруулах)-д оршино»	Туульчийн тууль хайлах онцлогийг тодорхойлох
Зорилт	Шинэ мэдлэг гаргах 3–5 дэд асуудал	Үр дүнг нэрлэнэ: «…-ыг харьцуулж ялгааг тогтоох»	Баатрын нэршлийн давтамжийн нягтыг тогтоох
Алхам	Хийх ажил; төлөвлөгөөнд бичнэ	Хугацаатай: «11 сард …»	Туулийг уншиж, мөр тоолж, Excel-д бүртгэх

Жишээ нь: зорилго

*«**Тиймээс** эл өгүүлэлд С. Чойсүрэнгийн хайлсан гурван туулийн гол баатрын нэр, нэршлийн давтамжийг **тооцоолж**, хэвшмэл хэллэгийн хэрэглээний зүй тогтлыг **гарган**, үүнд үндэслэн **С. Чойсүрэнгийн тууль хайлах онцлогийг тодорхойлох** юм.»*

(х.173–174)

- **«Тиймээс»** — судлагдсан байдлын дутуу зүйлээс зорилго гарч ирсэн
- **«тооцоолж», «гарган»** — зорилт руу хөтлөх ажил
- **«тууль хайлах онцлогийг тодорхойлох»** — эцсийн зорилго
- «Зорилго» гэсэн шошгогүй, удиртгал дотор «уусжээ»
- Хураангуйд: *«…туулийн хэл найруулгын өвөрмөц онцлогийг тодорхойлоход чиглэсэн»* (х.172)

Жишээ нь: зорилт

*«**Үүний тулд:***

*I. Задлан шинжлэх туульсыг сонгон, туульд гарч буй гол болон дагалдах баатрын нэрийн давтамжийг тоолон, тэдгээрийн өгүүлэмжийн эзлэх хувийг нягтацын аргаар **тодорхойлох**;*

*II. Өргөтгөсөн чимэг үгсийн хэрэглээний давтамжийг **тогтоож**, ямар тохиолдолд илэрч байгааг **тодорхойлох**;*

*III. Судалж буй туульст ижил зүй тогтол буй эсэхийг **шинжилж**, ерөнхийлөн дүгнэснээр, тухайн туульдахь баатрын хэвшмэл хэллэгийн үүргийг **тодорхойлох** юм.»* (х.174)

- **«Үүний тулд»** — зорилт бүр зорилгод үйлчилж байна
- Үйл үг: тодорхойлох, тогтоох, шинжлэх — бүгд «-х» хэлбэр
- I = тоолох, II = тоолох + нөхцөл, III = харьцуулж ерөнхийлөх
- «Зорилт» гэж нэрлээгүй, арга зүйн алхам хэлбэрээр бичсэн

Зорилт = [юуг] + [ямар аргаар] + [ямар үр дүн гаргах]

*«…баатрын нэрийн давтамжийг **тоолон** [арга], … эзлэх хувийг **нягтацын аргаар** [арга] **тодорхойлох** [зорилт]»* (Лхагвачимэг, х.174)

Жишээ нь: эх хэрэглэгдэхүүн

«Судалгааны эх хэрэглэгдэхүүний хувьд, С. Чойсүрэнгийн хайлсан "Галзуу хар хөхөл" (1938 мөр), "Эзэн улаан бодон" (2246 мөр), "Бужин даваа хаан" (4725 мөр) туулийг сонгон судалсан юм.» (х.174)

Шалгуур	**Өгүүлэлд**
Эх, хэвлэл	«Нэрт туульч С. Чойсүрэнгийн туульс», эмхэт. Б. Катуу, 2010
Хэмжээ	3 тууль, нийт 8909 мөр
Сонгосон шалтгаан 1	мөрийн тоогоор ялгаатай туулиудад хэвшмэл хэллэг ижил давтагдах эсэхийг тогтоох
Сонгосон шалтгаан 2	гурвуулаа эцэг–хүү буюу хоёр үеийн үйл явдлыг өгүүлдэг
Сонгосон шалтгаан 3	урт нь өөр ч өгүүлэмж төстэй туульд нийтлэг зүй тогтол илрэх эсэхийг шалгах

Жишээ нь: онол

«…Милман Парри, Альберт Лорд нарын “Аман хэвшил тогтолцоо”… -ыг гол үндэс болгож, … Б. Цогжингийн “Аман туулийн шүлэг зүй” бүтээлд тулгуурлан…» (х.174)

Онолын ойлголт	**Өгүүлэл дэх тодорхойлолт**	**Хуудас**
Хэвшмэл хэллэг [formula]	«давтагдах шинж бүхий хэвшин тогтсон холбоо үг»	175
Давтамжийн нягт [formulaic density]	«тодорхой нэгэн нэгжид хэвшмэл хэллэгийн дахин илрэх давтамж»	175
Өвөрмөц чимэг үг [epithet]	онцлогийг илтгэх тэмдэг нэр; «ямагт нэрийдлийн нэг хэсэг болдог»	177
Өргөтгөсөн чимэг үг	хэд хэдэн мөр нэмж, баатрыг олон мөрт шүлгээр тодотгосон	177
Бүтцийн загвар	Цогжин: «үндсэн холбоо үг + чимэг үг + өгүүлбэрийн гишүүн» → өгүүлэлд: «нутаг + албат + морь + [чимэг үг] баатар»	177

Жишээ нь: ойлголтыг хэмжигдэхүүн болгох

Нягт = баатрыг дүрсэлсэн мөр ÷ нийт мөр × 100

- «Галзуу хар хөхөл»: 79 ÷ 1938 × 100 ≈ 4%
- «Хэвшмэл хэллэг олон» биш, тоогоор хэлсэн

Таны сэдэвт «эсрэгцэл», «анимус», «алдаа»-г юугаар таньж, юугаар тоолох вэ?

Жишээ нь: арга зүй ба арга

	Арга зүй	**Арга**
Тайлбарлавал:	Онол + ажлын дараалал	Өгөгдлийг цуглуулж, боловсруулах тодорхой хэрэгсэл
Өгүүлэлд:	Парри–Лордын онол, Цогжингийн «Аман туулийн шүлэг зүй»; I → II → III алхам	Тоон: мөр тоолох, нягтацын томьёо. Чанарын: ангилах (Хүснэгт 2–4), тайлбарлах. Гурван туулийг харьцуулах
Хураангуйд: (х.172)	*«Судалгааны арга зүй нь … “Аман хэвшил тогтолцооны онол”-д үндэслэн…»*	*«…хэвшмэл хэллэгийн хэрэглээг тоон болон чанарын аргыг ашиглан судаллаа»*

Арга нь томьёо болсон:

Давтамжийн нягт = баатрыг дүрсэлсэн нийт мөрийн тоо ÷ туулийн нийт мөрийн тоо × 100%
(х.175)

Жишээ нь: шинэлэг тал, ач холбогдол

«Судалгааны ач холбогдол нь хувь тулъчийн тууль хайлах онцлогийг судлах, хайлсан туульсын бүтцийг нарийвчлан шинжлэх, тулъчийн онцлог бүхий “нэгэн амны үг”-ийг тодорхойлоход орших юм.» (х.172, хураангуй)

- **Шинэлэг тал:** тусгайлан бичээгүй — судлагдсан байдлаас уншигдана: өмнө нь үйл явдлыг товчилсон, энэ өгүүлэл давтамжийг тоогоор тооцсон
- **Ач холбогдол:** зөвхөн хураангуйд, зорилгыг давтсан хэлбэртэй.
- **Дутуу:** үр дүнг хэн, юунд ашиглах вэ? (тууль судлаач, бусад туульчтай харьцуулах…)
- **Үргэлжлэл судалгаа:** 3 тууль → 6 тууль, аман хэвшилт шүлгийн тогтолцоо.

«Шинээр юу нэмэх вэ?»-г нэг өгүүлбэрээр бичнэ.

Үндсэн хэсэгт юу орох вэ?

- Зорилт бүрийг нэг бүлэг (дэд гарчиг) болгон бичнэ
- Онолын ойлголтын тодорхойлолт, эхэд таних шалгуур
- Эх хэрэглэгдэхүүнээс түүвэрлэсэн жишээ, баримт
- Тоо баримтыг хүснэгт, графикаар харуулна
- Хүснэгт, график бүрийг тайлбарлаж, дүн шинжилгээ хийнэ
- Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулна
- Бүлэг бүрийг дэд дүгнэлтээр төгсгөнө

Жишээ нь: зорилт → бүлэг → дүгнэлт

Зорилт	**Үндсэн хэсгийн бүлэг**	**Дүгнэлтэд**
I. Нэрийн давтамж, нягт	*«Нэг. Туульсын гол баатрын нэр, нэршлийн давтамж»* (х.175)	*«…давтамжийн нягт нь 0,3-4,0%-ийн хооронд хэлбэлзэж байна»*
II. Өргөтгөсөн чимэг үг, нөхцөл	*«Хоёр. Өргөтгөсөн чимэг үгсийн хэрэглээг тодорхойлох нь»* (х.176)	*«Гурван туульд баатрыг танилцуулахдаа ямагт өргөтгөсөн чимэг үгийг хэрэглэж буй нь зүй тогтол юм»*
III. Нийтлэг зүй тогтол	*«Гурав. Өвөрмөц хийгээд өргөтгөсөн чимэг үгийн хэрэглээ, зүй тогтол»* (х.180)	*«…баатрыг танилцуулахад "өргөтгөсөн чимэг үг"-ээр, … ерийн явдлын үед дүрслэхэд "өвөрмөц чимэг үг"-ээр тодотгодог гэх зүй тогтол»*

Үндсэн хэсгийн эхний догол мөрөнд гурван бүлгээ урьдчилан зарласан: «нэгт…; хоёрт…; гуравт…» (х.175)

Дүгнэлтийг хэрхэн бичих вэ?

- Зорилт бүрд дарааллаар нь хариулна
- Гол үр дүнг тоо, баримтаар товч хэлнэ
- Удиртгалд дэвшүүлсэн таамаглал батлагдсан эсэхийг заана
- Өмнөх судалгаанаас юугаараа ялгарсныг хэлнэ
- Судалгааны хязгаарлалтыг шударгаар дурдана
- Цаашид судлах асуудлыг дэвшүүлнэ
- Үндсэн хэсэгт байхгүй шинэ зүйл оруулахгүй

Жишээ нь: дүгнэлт зорилготойгоо уялдсан уу?

Зорилгод:
«...үүнд үндэслэн С. Чойсүрэнгийн ***тууль хайлах онцлогийг тодорхойлох*** *юм.»* (х.174)

Дүгнэлтийн эхний өгүүлбэр:
«Энэхүү илтгэлд ... давтамжийн нягтыг тооцож, өвөрмөц болон өргөтгөсөн чимэг үгийг хэрэглээг задлан шинжиллээ.» (х.182)

- **Нэмэх өгүүлбэр:** *«Иймд С. Чойсүрэнгийн тууль хайлах онцлог нь ... -д илэрч байна.»*
- **Уялдсан:** зорилт бүрт нэг догол мөр (2, 3, 4-р догол)
- **Уялдсан:** хариултыг тоо (0,3–4,0%), бүтэц («нутаг + албат + морь + [чимэг үг] + баатар»)-аар хэлсэн
- **Дутуу:** «тууль хайлах онцлог» гэсэн үг дүгнэлтэд дахин гараагүй.

Жишээ нь: хүснэгт ба дүгнэлтийг тулгаж унших

Тууль	Нийт мөр	Баатрыг дүрсэлсэн мөр	Нягт
Галзуу хар хөхөл	1938	79	4,0%
Эзэн улаан бодон	2246	77	3,4%
Бужин даваа хаан	4725	81	1,7%

Дүгнэлтэд: «…нягт ойролцоо… тоо хэмжээ нь тогтмол байж болох таамаглалыг баталж байна»

«Ойролцоо», «тогтмол», «их», «бага» гэсэн үгээ тоогоор шалгасан уу? 4,0 ба 1,7 хоёр ойролцоо биш.

Аль хэмжигдэхүүний тухай ярьж байна вэ? Нягт, тоо, хувь гэх мэт хэмжигдэхүүнийг хооронд нь андуурахгүй байх.

«Батлагдлаа» гэж бичих тухайд: Таамаглалыг удиртгалд урьдчилан бичсэн бол л тэгж бичнэ.

Үгүй бол «…гэж үзэх үндэс байна, цаашид шалгах» гэж бичнэ. Энд гурван тууль л байгаа учир хянамгай бичнэ.

Ном зүйд юу орох вэ?

- Эх бичвэрт эш татсан бүтээл бүр ном зүйд орно
- Ном зүйд байгаа бүтээл бүр эх бичвэрт дурдагдсан байна
- Бүх бүтээлийг нэг загвараар бичнэ
- Зохиогч, он, гарчиг, хэвлэсэн газар, хэвлэлийн газар, хуудас
- Цахим эх сурвалжид холбоос, хандсан огноог бичнэ
- Цагаан толгойн дарааллаар жагсаана

НОМ ЗҮЙ

Эх хэрэглэгдэхүүн

Нэрт туульч С. Чойсүрэнгийн туульс, (2010), Эмхэтгэн боловсруулж, эрдэм шинжилгээний удиртгал, тайлбар бичсэн Б. Катуу, УБ., “Shiny Printing” ХХК.

Судалгааны бүтээл

Аргил цагаан өвгөн, (1985), Эмхэтгэн боловсруулсан Р. Борджанова, Т. Г., Творчество западномонгольского сказителя С. Чойсурена, (1987), (Аман зохиол судлал, XVII боть, 3-р дэвтэр), УБ., Шинжлэх ухааны академийн хэвлэх.

Монгол ардын баатарлаг туульс, (1960), Эмхэтгэн боловсруулж, удиртгал тайлбар үйлдсэн Г. Ринчинсамбуу, УБ., Улсын хэвлэлийн газар.

Цогжин, Б., (2010), Аман туулийн шүлэг зүй, УБ., “Бэмби сан” хэвлэх үйлдвэр.

Жишээ нь: ном зүйг эх бичвэртэй тулгах

Эх бичвэрт	Ном зүйд	Шалгах асуулт
Цогжин, … 2020 (зүүлт 14)	Цогжин, (2010)	Аль он нь зөв бэ?
Б. Катуу, 1999; 2001 (зүүлт 9, 10)	байхгүй	Эш татсан бол яагаад ороогүй вэ?
П. Хорлоо (бичвэрт) → зүүлт 8: Сампилдэндэв	Сампилдэндэв	Хэний бүтээл, нэр нь аль вэ?
Г. Ринченсамбуу (бичвэрт)	Г. Ринчинсамбуу	Нэрийн бичлэг нэг байх
Парри, Лорд (гол онол)	бүтээл нь байхгүй	Онолын эх сурвалжийг оруулах уу?

- Шүүмж биш, дасгал: өөрийн ажлынхаа зүүлт бүрийг ном зүйтэй ингэж нэг нэгээр тулгаарай.

Хавсралтад юу орох вэ?

- Үндсэн хэсэгт багтаагүй том хүснэгт, бүрэн жагсаалт
- Бүртгэлийн хүснэгт, кодлох зааврын загвар
- Асуулга, ярилцлагын асуултын жагсаалт
- Авиалагч, оролцогчийн мэдээлэл (нэрийг нууцалсан)
- Нэмэлт график, зураг
- Хавсралт бүр дугаар, гарчигтай, эх бичвэрт дурдагдсан

Шалгах хуудас (1)

- Судалгааны асуултаа асуултын хэлбэрээр бичсэн
- Зорилт бүр нэг асуултад хариулна, алхам биш
- Хэрэглэгдэхүүний хэвлэл, он, тоо хэмжээ, сонгосон шалгуур бий
- Шинжилгээний нэгж ба бүртгэлийн хүснэгтийн загвартай
- Онолын ойлголт бүрийг эхэд таних шалгууртай болгосон

Шалгах хуудас (2)

- Судлагдсан байдалд 8-аас доошгүй бүтээл, гадаад бүтээлтэй
- Он сар зөв (2026.11–2027.05), сар бүр хэмжигдэхүйц үр дүнтэй
- Эх бичвэрт дурдсан бүтээл бүр ном зүйд нэг загвараар орсон
- Бусдын бичвэрийг өөрийн үгээр бичсэн эсвэл эш татсан
- Хүн оролцсон бол: зөвшөөрөл, нэрийг нууцлах журамтай

Асуулт, хэлэлцүүлэг

Засварласан төлөвлөгөөгөө удирдагч багшдаа илгээнэ үү